



Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга судалгаа

2019

Агуулга

ОРШИЛ	2
ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ	3
НЭГ. Малчдын тоо тэдний соёл ахуйн үзүүлэлт	6
I.1 Малчдын тоо, насны бүтэц	6
I.1.2 Малчдын соёл ахуйн үзүүлэлт	7
ХОЁР. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн	8
II.1. Малын тоо бүтэц	8
II.2 Хувийн /амины/ малын тоо бүтэц	13
II.3 Малтай өрхийн малын бүлэглэлт	13
II.4. Хээлтэгч мал	14
II.5 Төл бойжилт	16
II.6 Том малын зүй бусын хорогдол	16
II.7 Малын хээл хаялт, сувайралт	17
II.8 Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо	18
II.9 Малын хэрэглээний зарлага	19
II.10 Сүргийн бүтэц	21
ГУРАВ. Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж	
III.1 Бэлчээрийн хүрэлцээ	22
III.2 Малын тэжээлийн үйлдвэрлэлт	23
III.3 Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж	24
ДҮГНЭЛТ	25

Оршил

Өмнөговь аймгийн эдийн засгийн хөгжилд Хөдөө аж ахуйн салбар өнөөг хүртэл тэргүүлэх байр суурийг эзэлсээр ирсэн бөгөөд цаашид ч мөн уул уурхайн салбарыг даган эрчимтэй хөгжүүлэх бодлого чиглэлийг баримталж байна.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

“Монгол Улсын Үндсэн хууль”-д “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, тэжээл, худаг усны тооллогыг 2018 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж явууллаа.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

Судалгааны зорилго: Аймгийн эдийн засагт Хөдөө аж ахуйн салбарын эзлэх байр суурь, цаашдын хандлагыг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

Судалгааны агуулга: Энэ зорилгоор мал аж ахуйн салбарын ирээдүйн хөгжил, малчдын амжиргааны талаар бодлого, малын тооны өсөлт өөрчлөлт, бүтэц, малын төллөлт, үржлийн байдал, зүй бус хорогдол, сувайралт, хээл хаялт, бэлчээрийн даац хүрэлцээ, хээлтэгч, хээлтүүлэгч, түүний тохироо болон малтай өрх, малчдын нийгмийн байдал, малын тооны өсөлт бууралтанд нөлөөлсөн үзүүлэлтүүдийг тодорхойлох, газар тариалангийн салбарын хувьд тариалалт, ургац хураалт, ургацын хэмжээг тооцов.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр	- 1 бод
1 тэмээ	- 1.5 бод
6 хонь	- 1 бод
8 ямаа	- 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ	- 5 хонь
1 адуу	- 7 хонь
1 үхэр	- 6 хонь
1 хонь	- 1 хонь
1 ямаа	- 0.9 хонь

Бог-д шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ	- 4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу	- 3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр	- 2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал	- тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

Тэмээ-Өмнөх оны төл,	2, 3 настай
Адуу-	Өмнөх оны төл, 2 настай
Үхэр-	Өмнөх оны төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур -	20-25
Азарга -	12-15
Бух -	35-45
Хуц, ухна -	25-30

Том малын зүй бус хорогдолд: Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага: Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс	-	0.45
Таримал тэжээл	-	0.35
Даршны ургамал	-	0.25
Гар тэжээл, хужир шүү	-	1.00
Төмс ногооны хаягдал	-	0.22
Үр тарианы хаягдал	-	0.90
Лай	-	0.40
Сүрэл	-	0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай: Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай: Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай: Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац: Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Нийт ургац: Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

1. МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ, АХУЙН БАЙДАЛ

1.1. Малчдын тоо, насны бүтэц:

хүснэгт 1

Өрх, малчдын тоо насны бүтэц

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017	
											хувь	зөрүү
Малтай өрх	7638	6894	6661	6619	6713	6771	6963	7172	7418	7496	101.1	78
Малчин өрх	6301	5628	5431	5131	5173	5216	5417	5647	5819	5951	102.3	132
Малчдын тоо	11612	10258	9751	9279	9226	9449	9588	9846	9635	9593	99.56	-42
Үүнээс: 16-34 насны	5614	4640	4154	3695	3534	3493	3473	3408	3084	3012	97.67	-72
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	4677	4388	4366	4544	4706	4944	5135	5353	5079	5151	101.4	72
Тэтгэврийн насны	1321	1230	1231	1040	986	1012	980	1085	1431	1430	99.93	-1
Нийт малчдаас эмэгтэй	5453	4809	4598	4403	4382	4408	4378	4503	4315	4269	98.93	0
Насны бүрэлдэхүүн %	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	-1
Үүнээс: 16-34 насны	48.3	45.2	42.6	39.8	38.3	37	36.2	34.6	32.01	31.4	98.1	1
35-аастэтгэвэрт гарах хүртэл насны	40.3	42.8	44.8	49	51	52.3	53.6	54.4	52.71	53.7	101.9	
Тэтгэврийн насны												
Бусад	11.4	12	12.6	11.2	10.7	10.7	10.2	11	14.85	14.9	100.3	0
Нийт малчдаас эмэгтэй %	47	46.9	47.2	47.5	47.5	46.7	45.7	45.7	44.78	44.5	99.36	0
Нэг малчин өрхөд ногдох малын тоо /толгойгоор/	278	180	225	276	320	354	379	409	456	436	95.61	-20

Эх сурвалж: 2009-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2018 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээгээр 7496 малтай өрх, үүнээс 5951 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Аймгийн хэмжээний нийт өрхийн 34.1 хувийг малтай өрх эзэлж байна.

2018 онд мал аж ахуйн салбарт 9593 малчид ажиллаж байна. Нийт малчдын 44.8 хувь нь буюу 4269 эмэгтэйчүүд байна.

Малчин өрхийн тоо өмнөх оныхоос 2.3 хувиар буюу 132 өрхөөр өссөн, малчдын тоо өмнөх оноос 0.4 хувиар буюу 42 малчнаар буурсан үзүүлэлт харагдаж байна.


Нийт малчин өрхийн 31.4 хувийг 16-34 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд, 53.7 хувийг 35-аас 59 насны хүмүүс харин үлдсэн 14.9 хувийг тэтгэврийн өндөр настай хүмүүс эзэлж байна. Өмнөх онуудтай харьцуулахад 16-34 насны залуучууд мал аж ахуй эрхлэх нь буурч, 35-59 насны хүмүүс, тэтгэврийн насны хүмүүс мал аж ахуй эрхлэх нь ихэссэн үзүүлэлт харагдаж байна.

2018 онд нэг малчин өрхөд 436 толгой мал оногдож байгаа нь өмнөх оноос 20 толгой малаар буурсан байна.

Зураг 1

МАЛЧДЫН ТОО НАСНЫ БҮТЭЦ

■ 2014 ■ 2015 ■ 2016 ■ 2017 ■ 2018



1.2. Малчдын соёл ахуйн үзүүлэлт .

2018 оны мал тооллогын дүнгээр нийт малчин өрхийн 77.3 хувь буюу 4599 өрх цахилгааны эх үүсвэртэй, 73.8 хувь буюу 4392 өрх телевизортой, 51.7 хувь буюу 3078 өрх автомашинтай, 48.7 хувь буюу 2898 өрх мотоциклтой, 0.1 хувь буюу 8 өрх трактортой байна.

Өмнөх онтой харьцуулахад цахилгааны эх үүсвэртэй өрх 40 өрхөөр буюу 0.9 хувиар, телевизортой өрх 1.7 хувиар, автомашинтай өрх 10.4 хувиар, мотоциклтой өрх 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Трактортой өрх 42.8 хувиар буурсан байна.

Малчдын соёл ахуйн үзүүлэлт


хүснэгт 2

	Өрхийн тоо							Малчин өрхийн тоонд эзлэх хувь						
	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Цахилгааны эх үүсвэртэй	3940	5317	4607	4654	4614	4559	4599	76.8	103	88.3	85.9	82.4	78.3	77.3
Телевизортой	3841	4142	4251	4267	4126	4318	4392	74.9	80.1	81.5	78.8	75.6	74.2	73.8
Автомашинтай	2405	2295	2412	2581	2449	2788	3078	46.9	44.4	46.2	47.6	45.7	47.9	51.7
Мотоциклтой	2792	2597	2705	2624	2638	2892	2898	54.4	50.2	51.9	48.4	46.5	49.7	48.7
Трактортой	17	28	21	23	24	14	8	0.3	0.5	0.4	0.4	0.4	0.2	0.1

Эх сурвалж: 2012- 2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Малчдын соёл ахуйн үзүүлэлт /2012-2018/

Зураг 2



2. МАЛ АЖ АХУЙН ТОО, БҮТЭЦ

2.1. Малын тоо.

2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Өмнөговь аймгийн 15 сумын 58 багт 2.6 сая толгой мал тоолуулж 2017 оныхоос 55.9 мянган толгой малаар буюу 2.1 хувиар буурсан байна.

Тооллогын дүнгээр тэмээний тоо 152281 толгой, адуу 96544 толгой, үхэр 26864 толгой, хонь 631412 толгойд, ямаа 1691339 толгойд хүрсэн байна. Өмнөх оныхоос тэмээ 11049 толгойгоор буюу 7.8 хувиар, хонь 17432 толгойгоор 2.8 хувиар өссөн, адуу 2107 толгойгоор 2.1 хувиар, үхэр 133 толгойгоор буюу 0.5 хувиар, ямаа 82189 толгойгоор буюу 4.6 хувиар тус тус буурсан байна.


Малын тоо
/төрлөөр/

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017	
									Хувь	Зөрүү
Бодоор *	330021	376964	425661	474842	519869	584394	661517	668482	101.1	6965
Толгойн тоо	1223459	1419253	1653264	1849043	2055765	2313963	2654388	2598440	97.9	-55948
Тэмээ	87837	97317	103120	112741	118584	130493	141232	152281	107.8	11049
Адуу	43366	50100	58164	66345	74170	85298	98651	96544	97.9	-2107
Үхэр	8732	10762	13374	16085	18653	22149	26997	26864	99.5	-133
Хонь	257444	299816	350811	397600	447008	520905	613980	631412	102.8	17432
Ямаа	826080	961258	1127795	1256272	1397350	1555118	1773528	1691339	95.4	-82189

* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг 1 бод, тэмээг 1.5 бод, 6 хонь 8 ямааг тус бүр 1 бод гэж тооцов.
Эх сурвалж: 2011-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Зураг 3

Малын өсөлтийн хувь /2018/



Зураг 3 - Нийт мал сүргийн өсөлтийн 65 хувийг ямаа, 24 хувийг хонь, 6 хувийг тэмээ, 4 хувийг адуу, үлдсэн 1 хувийг үхэр сүргийн өсөлт эзэлж байна.

Малын тоо / сумдаар/


Сумын нэр	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017
Баяндалай	138201	153575	168829	180270	190396	175787	92.3
Баян-Овоо	89577	96465	107805	124227	147595	142224	96.4
Булган	110534	131464	142671	165837	194503	205265	105.5
Гурвантэс	143640	140895	166228	181562	205078	187458	91.4
Мандал-Овоо	93002	116590	135139	157716	185166	209916	113.4
Манлай	117787	128835	133820	160576	188781	205418	108.8
Номгон	197239	216984	244795	262296	289869	262292	90.5
Ноён	92895	105200	116669	119638	126694	108306	85.5
Сэврэй	119881	130386	147538	156286	177238	172662	97.4
Ханбогд	126003	126467	133013	151446	172774	165527	95.8
Ханхонгор	127966	156261	174303	204635	242353	236686	97.7
Хүрмэн	106674	121208	137961	145908	159572	142790	89.5
Цогт-Овоо	61866	73695	85766	105999	131945	140197	106.3
Цогтцэций	65741	75156	82429	102660	130758	135026	103.3
Даланзадгад	62258	75862	78799	94907	111666	108886	97.5
Дүн	1653264	1849043	2055765	2313963	2654388	2598440	97.9

Эх сурвалж: 2013-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр нийт мал сүрэг өмнөх онтой харьцуулахад 2.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 4

Малын тоо /сумдаар/



Аймгийн дундаж малын тоо 173229 толгой болж малын тоогоор 7 сум аймгийн дунджаас дээгүүр, 8 сум дунджаас доогуур байна.

Малын тооны өсөлт, бууралтанд нөлөөлсөн хүчин зүйл

/мян.толгой/	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	хүснэгт 5	
									2018/2017	
									Хувь	Зөрүү
Бойжуулсан төл	406786	393591	469222	450151	530744	540484	664257	399966	60.2	-264291
100 эхээс бойжуулсан төл / толгойгоор /	78	82	82	68.1	68.4	64	69	38	55.1	-31
Хээлтэгч малын тоо	477428	575182	660840	776420	845476	963150	1066064	1174356	110.2	108292
Том малын зүй бус хорогдол	9399	8815	9727	11128	17326	10089	11251	61994	551.0	50743
Хээл хаясан хээлтэгч	1904	978	846	2241	2304	5370	2306	11240	487.4	8934
Сувайрсан хээлтэгч	95400	79705	93158	183799	206988	278868	276346	593355	214.7	317009

Эх сурвалж: 2011-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Малын өсөлтөнд нөлөөлдөг гол хүчин зүйл болох бойжсон төлийн тоо өмнөх оноос 264.3 мянган төлөөр буурч , том малын зүй бусын хорогдол өмнөх оноос 50743 малаар буюу 5.5 дахин , хээлтэгч малын тоо 10.2 хувиар өссөн, сувайрсан хээлтэгч өмнөх оноос 2.1 дахин , хээл хаясан хээлтэгч 4.9 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 5



2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр бойжуулсан төл 399.9 мянгад хүрсэн нь өмнөх оны мал тооллогын дүнгээс 264.3 мянган төлөөр буюу 39.8 хувиар буурсан үзүүлэлттэй харагдаж байна.



Зураг 6

Хээлтэгч малын тоо нь 2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр 1174.4 мянгад хүрсэн нь өмнөх мөн үеэс 108.3 мянгаар буюу 10.2 хувиар өссөн байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

хүснэгт 6

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	100	100	100	100	100	100	100	100	100	100	100	100
Тэмээ	5.4	4.8	4.9	8.3	7.2	6.9	6.2	6.1	5.8	5.6	5.3	5.9
Адуу	3.3	3.1	3.1	3.7	3.5	3.5	3.5	3.6	3.6	3.7	3.7	3.7
Үхэр	0.7	0.7	0.7	0.7	0.7	0.8	0.8	0.9	0.9	1	1.0	1.0
Хонь	21.2	20.8	21.4	21.1	21	21.1	21.2	21.5	21.7	22.5	23.1	24.3
Ямаа	69.4	70.5	69.9	66.2	67.5	67.7	68.2	67.9	68	67.2	66.8	65.1


Эх сурвалж: 2007-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийг авч үзвэл өмнөх оноос тэмээн сүрэг 0.6 хувиар, хонин сүрэг 0.8 хувиар өсч , ямаан сүрэг 1.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Бог малын 75.0 орчим хувийг хонь, 25.0 орчим хувийг ямаа эзэлж байх үед сүргийн бүтэц болон малын бэлчээр ашиглалтад зохистой байдаг. Бог малын дотор хонин сүргийн эзлэх хувь нь 27.2, ямаан сүрэг 72.8 хувийг тус тус эзэлж байгаа нь дээрх харьцаа сүүлийн жилүүдэд ихээхэн алдагдаж байгааг илэрхийлж байна.

зураг 7

Мал сүргийн бүтэц /2018/



Манай аймгийн хувьд нийт сүрэгт эзлэх ямааны хувь улсдаа хамгийн өндөр байгаа нь мал сүргийн бүтцэд зохисгүй өөрчлөлт гарч байгаа нь анхаарал татсан асуудал болж байна. Цаашид ямаан сүргийн тоо толгойн өсөлт үргэлжилвэл байгаль орчин, бэлчээрийн хүрэлцээнд муугаар нөлөөлөх нь тодорхой байна.

2.2 . Хувийн / амины / малын тоо:

2018 онд хувийн малын тоо 2587.4 мянган толгойд хүрч, нийт малын 99.6 хувийг эзэлж байна. Тэмээн сүргийн 99.3 хувь, адуун сүргийн 99.9 хувь, үхэр сүргийн 99.0 хувь, хонин сүргийн 99.4 хувь, ямаан сүргийн 99.6 хувь нь хувийн аж ахуйд байна. Хувийн малын тоо өмнөх оноос 55.0 мянган толгой буюу 2.1 хувиар буурсан байна.

Хувийн малтай өрх, малын тоо / төрлөөр/

мян.толгой			хүснэгт 7				
Он	Малтай өрхийн тоо мян.өрх	Бүгд	Үүнээс				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2003	7.4	892.4	69.6	36.6	5.9	199.7	580.6
2004	7.3	1054.1	70.2	40.7	7.3	227.6	708.3
2005	7.3	1105.9	70.3	42.6	8.5	243.4	741.1
2006	7.2	1140.3	70.7	42.1	8.6	249.2	769.7
2007	7.3	1383.8	74.6	46.3	10	293.4	959.5
2008	7.6	1666.1	80	53	12.3	347.2	1173.6
2009	7.6	1738.5	84.9	53.6	12.9	371.7	1215.3
2010	6.9	1002.2	83.2	37.6	7.5	210.4	663.6
2011	6.7	1216.7	87.5	43.4	8.7	255.4	821.8
2012	6.6	1409.2	96.6	50.1	10.7	296.8	954.9
2013	6.6	1642.1	102.4	58.2	13.3	347.4	1120.9
2014	6.7	1837.8	111.9	66.3	15.9	394.1	1249.4
2015	6.9	2043.4	117.8	74.2	18.5	443	1389.9
2016	7.1	2300.9	129.6	85.2	22	516.7	1547.4
2017	7.4	2642.4	140.2	98.5	26.9	610.3	1766.5
2018	7.5	2587.4	151.2	96.5	26.7	628.0	1685.0

Эх сурвалж: 2003-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2018 оны байдлаар хувийн аж ахуйн нийт малын 65.1 хувийг ямаа, 24.3 хувийг хонь, 5.8 хувийг тэмээ, 3.7 хувийг адуу, 1.0 хувийг үхэр эзэлж байна.

2.3 Малтай өрхийн малын бүлэглэлт.

	Малтай өрхийн тоо			Нийт өрхөд эзлэх хувь			Малын тоо /мян.толгой/		
	2016	2017	2018	2016	2017	2018	2016	2017	2018
Бүгд	7172	7418	7496	100	100	100	2 302	2643	2587
10 хүртэл малтай	105	87	106	1.46	1.2	1.4	1	1	1
11-30 малтай	445	400	441	6.2	5.4	5.9	9	8	9
31-50 малтай	469	451	479	6.54	6.1	6.4	19	19	20
51-100 малтай	983	953	954	13.71	12.8	12.7	72	70	71
101-200 малтай	1271	1207	1269	17.72	16.3	16.9	189	177	187
201-500 малтай	2343	2399	2393	32.67	32.3	31.9	778	798	797
501-999 малтай	1179	1419	1372	16.44	19.1	18.3	781	961	923
1000-1499 малтай	337	447	427	4.7	6.0	5.7	380	508	480
1500-2000 малтай	31	40	38	0.43	0.5	0.5	51	67	63
2001-ээс дээш малтай	9	15	17	0.13	0.2	0.2	20	33	37

Эх сурвалж: 2016-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нийт өрхийн 1.4 хувийг 10 хүртэл малтай өрх, 5.9 хувийг 11-30 малтай өрх, 6.4 хувийг 31-50 малтай өрх, 12.7 хувийг 51-100 малтай өрх, 16.9 хувийг 101-200 малтай өрх, 31.9 хувийг 201-500 малтай өрх, 18.3 хувийг 501-999 малтай өрх, 5.7 хувийг 1000-1499 малтай өрх, 0.5 хувийг 1500-2000 малтай өрх, үлдсэн 0.2 хувийг 2000 –с дээш малтай өрх эзэлж байна.

Малтай 1 өрхөд ногдох малын тоо, бүлэглэлтээр

хүснэгт 9

	2015	2016	2017	2018	2018 он				
					Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Бүгд	293	321	356	345	20	13	4	84	225
10 хүртэл малтай	7	7	7	7	1	1	1	1	2
11-30 малтай	21	21	21	21	1	2	2	4	12
31-50 малтай	41	41	41	41	3	2	2	8	27
51-100 малтай	73	74	74	74	6	4	2	17	47
101-200 малтай	148	149	147	147	11	6	2	31	97
201-500 малтай	330	332	333	333	20	12	3	68	230
501-999 малтай	656	663	677	672	35	23	6	165	443
1000-1499 малтай	1115	1128	1137	1123	64	46	10	337	665
1500-2000 малтай	1639	1651	1666	1662	105	74	27	520	936
2001-ээс дээш малтай	2191	2232	2215	2204	146	79	6	801	1171

Эх сурвалж: 2015-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Аймгийн дунджаар нэг малтай өрхөд 345 мал оногдож байгаа нь 2017 оноос 11 толгой малаар буурсан байна. Малтай нэг өрхөд 20 тэмээ, 13 адуу, 4 үхэр, 84 хонь, 225 ямаа ногдож байна.

2.4 Хээлтэгч мал.

2018 онд 1174.4 мянган толгой хээлтэгч тоологдсон нь өмнөх оноос 10.2 хувиар буюу 108.3 мянган толгойгоор өссөн байна. Төрлөөр нь авч үзвэл ингэ 9.0 хувиар, гүү 3.2 хувиар, үнээ 3.7 хувиар, Эм хонь 13.0 хувиар, Эм ямаа 9.6 хувиар тус тус өсчээ.

Хээлтэгч малын тоо


мян.толгой	2012	2013	2014	2015	2016	2017	2018	хүснэгт 10	
								2018/2017	
								хувь	зөрүү
Ингэ	33.3	35.4	37.5	39.7	44	47.6	51.9	109.0	4.3
Гүү	15.1	17	20.2	23.2	27.3	31.3	32.3	103.2	1.0
Үнээ	4.2	5.2	6.4	7.6	8.9	10.5	10.8	103.7	0.4
Эм хонь	126.2	145.2	172	191.4	220.5	253.1	286.0	113.0	32.9
Эм ямаа	396.4	458.1	540.3	583.6	662.4	723.6	793.3	109.6	69.7
Дүн	575.2	660.8	776.4	845.5	963.2	1066.1	1174.4	110.2	108.3

Эх сурвалж: 2011-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Хээлтэгч мал нь нийт малын 45.2 хувийг эзлэж байгаа бөгөөд тэмээн сүргийн 34.1 хувийг, адуун сүргийн 33.5 хувийг, үхэр сүргийн 40.4 хувийг, хонин сүргийн 45.3 хувийг, ямаан сүргийн 46.9 хувийг тус тус эзэлж байна.

Хээлтэгч
/төрлөөр ,хувь/


Зураг 8



Нийт хээлтэгчийн 4.0 хувийг ингэ, 3.0 хувийг гүү, 1.0 хувийг үнээ, эм хонь 24.0 хувь, эм ямаа 68.0 хувийг тус тус эзэлж байна.

Хээлтэгч малын тоо /2003-2018 он/

Зураг 9



Сүүлийн жилүүдэд хээлтэгч малын тоо тогтмол өсч байсан боловч 2010, 2011 онуудад буурч, 2012 оноос өсөх хандлагатай болсон байна.

2.5 Төл бойжилт .

2018 онд гарсан төлийн 96.1 хувь нь буюу 399.9 мянган төл бойжуулсан байна.. Бойжсон төлийн тоо 2017 оныхоос 264.3 мянган толгойгоор буурсан үзүүлэлттэй байна. Төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл гарсан ботгоны 98.9 хувь, унаганы 93.7 хувь, тугалны 98.3 хувь, хурганы 97.7 хувь, ишигний 94.9 хувийг бойжуулсан байна.

Төл бойжилт

хүснэгт 11

	2014	2015	2016	2017	2018	Үүнээс					2018/ 2017
						ботго	унага	тугал	хурга	ишиг	хувь
Гарсан	457018	540719	543751	670614	416276	23523	12545	5213	143596	231399	62.1
Бойжсон	450151	530741	540484	664257	399966	23264	11752	5124	140271	219555	60.2
Хорогдсон	6867	9978	3267	6357	16310	259	793	89	3325	11844	256.6
Бойжилтын хувь	98.5	98.2	99.4	99.1	96.1	98.9	93.7	98.3	97.7	94.9	97.0

Эх сурвалж: 2014-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2018 онд аймгийн дунджаар 100 эхээс 38 төл бойжуулсан байна. Энэ онд 100 эхээс бойжуулсан төл нь урьд 5 төрөл дээрээ буурсан үзүүлэлттэй байна.

100 эхээс бойжуулсан төл

хүснэгт 12

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017
Бүгд	90	75	8	78	82	82	68	68	64	69	38	55.1
Ингэ	56	50	45	45	59	45	55	44	54	46	49	106.5
Гүү	82	69	13	76	74	81	67	65	61	65	37	56.9
Үнээ	87	76	25	74	80	87	74	69	65	70	49	70.0
Эм хонь	95	85	11	87	89	90	80	77	79	81	55	67.9
Эм ямаа	91	73	5	44	83	82	65	67	60	66	30	45.5

Эх сурвалж: 2008-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2.6 Том малын зүй бүсын хорогдол.

2018 онд оны эхний малын 2.3 хувь нь буюу 62.0 мянган толгой мал хорогдсон нь 2017 оноос 50743 толгой малаар буюу 5.5 дахин өссөн байна. Нийт хорогдсон малын 78.9 хувийг ямаа сүрэг, 15.4 хувийг хонин сүрэг, 3.1 хувийг адуу сүрэг, 0.9 хувийг тэмээ сүрэг, 1.8 хувийг үхэр сүрэг тус тус эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол


хүснэгт 13

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017	Зөрүү
Бүгд	9399	8815	9727	11128	17326	10089	11251	61994	551.0	50743
Тэмээ	462	288	364	354	481	244	190	546	287.4	356
Адуу	336	215	196	402	582	228	211	1915	907.6	1704
Үхэр	99	57	49	90	109	129	74	1096	1481.1	1022
Хонь	2232	2179	2454	2406	2667	2310	2463	9533	387.0	7070
Ямаа	6270	6076	6664	7876	13487	7178	8313	48904	588.3	40591

Эх сурвалж: 2011-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Зүй бус хорогдол /2008-2018 он/

Зураг 10



2.7 Малын хээл хаялт, сувайралт.

2018 онд оны эхний хээлтэгч малын 0.4 хувь нь буюу 11240 толгой хээлтэгч хээл хаяж, 22.4 хувьтай тэнцэх 593.4 мянган хээлтэгч сувайрсан байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 604.6 мянгад хүрч түүний 98.1 хувийг сувайрсан хээлтэгч, 1.9 хувийг хээл хаясан хээлтэгч мал тус тус эзлэж байна.

Хээл хаяж, сувайрсан хээлтэгч малын тоо

хүснэгт 14

	Хээл хаясан хээлтэгч						Сувайрсан хээлтэгч					
	2013	2014	2015	2016	2017	2018	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	846	2241	2304	5370	2306	11240	93158	183799	206988	278868	276346	593355
Ингэ	3	3	79	13	9	67	280	535	294	496	580	1262
Гүү	26	37	81	130	167	524	2802	5484	6480	8584	9597	16990
Үнээ	2	10	20	19	65	38	672	1457	1970	2551	2743	4945
Эм хонь	79	372	319	309	178	901	16239	27969	37856	42666	45901	106855
Эм ямаа	736	1819	1805	4899	1887	9710	73165	148354	160388	224571	217525	463303

Эх сурвалж: 2013-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Хээл хаясан хээлтэгч өмнөх онтой харьцуулахад 4.9 дахин, сувайрсан хээлтэгч 2.1 дахин тус тус өссөн байна.

Оны эхний хээлтэгчид хээл хаялт, сувайралтын эзлэх хувь


хүснэгт 15

	Хээл хаясан хээлтэгч						Сувайрсан хээлтэгч					
	2013	2014	2015	2016	2017	2018	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	0.1	0.3	0.3	0.6	0.2	0.4	16.2	23.7	24	33	28.7	22.4
Ингэ	0	0	0.2	0	0.0	0.0	0.8	1.4	1	1.2	1.3	0.9
Гүү	0.2	0.2	0.3	0.6	0.6	0.5	18.5	27.2	28	37	35.1	17.2
Үнээ	0	0.2	0.3	0.3	0.7	0.1	15.9	22.9	26	33.7	30.8	18.3
Эм хонь	0.1	0.2	0.2	0.2	0.1	0.1	12.9	16.3	20	22.3	20.8	17.4
Эм ямаа	0.2	0.3	0.3	0.8	0.3	0.5	18.5	27.5	27	38.5	32.8	26.1

Эх сурвалж: 2013-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Хээл хаялт, сувайралт

Зураг 11



2.8. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь малын бүх төрөл дээр алдагдсан хэвээр байгааг анхаарч үзэх хэрэгтэй байна.

2018 онд 16.7 мянган толгой хээлтүүлэгч мал тоологдож 2017 оноос 2.7 хувь буюу 471 толгойгоор буурсан байна. Өмнөх онтой харьцуулахад хээлтүүлэгч мал тэмээ, адуу, үхэр 3-н төрөл дээр өссөн, хонь ямаа 2 төрөл дээр буурсан үзүүлэлттэй байна.

Хээлтүүлэгч малын тоо

хүснэгт 16

	Хээлтүүлэгч мал						
	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	11637	12382	13375	14400	15971	17242	16771
Буур	1000	1027	1070	1111	1226	1275	1332
Азарга	2379	2594	2887	3248	3667	4044	4294
Бух	205	251	293	357	429	459	485
Хуц	2977	3111	3359	3628	4121	4430	4351
Ухна	5076	5399	5766	6056	6528	7034	6309

Эх сурвалж: 2012-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа тэмээн сүргийн хувьд 20-25 байхад 39, адуун сүргийн хувьд 12-15 байхад 8, үхэр сүргийн хувьд 35-45 байхад 22 байна, харин бог малын хувьд нэг хээлтүүлэгчид ноогдох хээлтэгчийн тоо 25-30 байхад хонь 66, ямаанд 126 байгаа нь үржлийн норм ихээхэн алдагдаж байгааг илтгэж байна. Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа өмнөх онтой харьцуулахад тэмээн сүрэг 2 хээлтэгчээр, хонин сүрэг 9 хээлтэгчээр, ямаан сүрэг 23 хээлтэгчээр тус тус нэмэгдсэн байна. Харин үхэр сүрэг 2 хээлтэгчээр буурсан байна.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

хүснэгт 17

	Үржлийн норм	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Буур	20-25*	33	34	35	36	36	37	39
Азарга	12-15.*	6	7	7	7	7	8	8
Бух	35-45*	21	21	22	21	21	23	22
Хуц	25-30*	42	47	51	53	54	57	66
Ухна	25-30*	78	85	94	96	101	103	126

Эх сурвалж: 2012-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

*-нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тоо.

2.9 Малын хэрэглээний зарлага.

2018 онд аймгийн хэмжээнд оны эхний малын 14.8 хувь буюу 393.9 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага 2017 оноос 81.3 мянган толгой малаар өссөн байна. Малтай нэг өрх дунджаар жилд 52.6 мал үүнээс 1.6 тэмээ, 1.6 адуу, 0.6 үхэр, 15.1 хонь, 33.8 ямааг хэрэглээндээ зориулж зарцуулсан байна. Аймгийн нийт өрхөөр тооцож үзэхэд нэг өрх дунджаар 18 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Малын хэрэглээний зарлага

хүснэгт 18

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	182.5	184.2	189.1	225.4	243.2	306.7	272.2	312.6	393.9
Тэмээ	7.7	8.1	8.1	8.8	9.6	10.2	9.3	9.5	11.7
Адуу	4.9	2.9	3.2	4	2.8	4.8	2.8	4.3	11.9
Үхэр	1.5	1.1	1	1	1.1	1.7	1.3	1.3	4.2
Хонь	44.1	52.4	46.7	59.6	67.3	80.3	75.8	84.1	113.3
Ямаа	124.3	119.6	130.1	152	162.4	209.7	182.9	213.5	252.8

Эх сурвалж: 2009-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Оны эхний малд эзлэх хувь

хүснэгт 19


	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	10.4	18.2	15.4	15.9	14.7	16.6	13.2	13.5	14.8
Тэмээ	9	9.7	9.2	9	9.3	9	7.8	7.2	8.3
Адуу	9.1	7.7	7.3	8	4.8	7.2	3.8	5.0	12.1
Үхэр	11.5	15.2	11.4	9.4	7.8	10.7	7	6.0	15.4
Хонь	11.7	24.6	18.1	19.9	19.1	20.2	17	16.1	18.5
Ямаа	10.1	17.9	15.7	15.8	14.4	16.7	13.1	13.7	14.3

Эх сурвалж: 2009-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Нийт хэрэглээнд зарцуулсан малын 92.9 хувийг бог мал, 7.1 хувийг бод мал эзэлж байна.

Малын хэрэглээний зарлага /төрлөөр/

Зураг 12



Зах зээлд худалдаж борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн малын тоо

хүснэгт 20

	Зах зээлд худалдан борлуулсан						Аж ахуйн дотоодод хэрэглэсэн					
	2013	2014	2015	2016	2017	2018	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	76193	85173	95525	104851	143414	207020	119693	129339	141479	145882	180797	152718
Тэмээ	4530	5429	4753	3549	6145	7664	2955	3198	3289	2935	3911	4032
Адуу	2385	2942	3021	1148	5359	9242	2145	2314	2765	1432	3605	3748
Үхэр	618	777	952	5294	1660	2920	899	1029	1217	3424	1836	1993
Хонь	19745	23342	25950	29478	39878	60594	34003	37914	40100	42795	51783	48247
Ямаа	48915	52683	60849	65382	90372	126600	79691	84884	94108	95296	119662	94698

Эх сурвалж: 2013-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

2018 онд зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн нийт малын 57.5 хувийг зах зээлд борлуулж, 42.5 хувийг аж ахуйн дотоодод хэрэглэсэн байна. Малтай нэг өрхөд дунджаар 28 толгой малыг зах зээлд борлуулж, 20 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

2.10 Сүргийн бүтэц.

2018 онд нийт сүргийн 15.4 хувь нь буюу 399.9 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 38.8 хувь буюу 1007.3 мянган толгой нь нас гүйцсэн эр мал, 45.2 хувь буюу 1174.4 мянган толгой хээлтэгч, 0.6 хувь буюу 16.8 мянган толгой хээлтүүлэгч гэсэн бүтэцтэй байна.

2018 оны сүргийн бүтэц


хүснэгт 21

	Толгойгоор					Нийт сүрэгт эзлэх хувь				
	Бүгд	Төл, өсвөр насны	Ажлын ба бэлтгэлийн насны эр	хээлтэгч	хээлтүүлэгч	Бүгд	Төл, өсвөр насны	Ажлын ба бэлтгэлийн насны эр	хээлтэгч	хээлтүүлэгч
Бүгд	2598440	399966	1007347	1174356	16771	100.0	15.4	38.8	45.2	0.6
Тэмээ	152281	23264	75823	51862	1332	100.0	15.3	49.8	34.1	0.9
Адуу	96544	11752	48161	32337	4294	100.0	12.2	49.9	33.5	4.4
Үхэр	26864	5124	10406	10849	485	100.0	19.1	38.7	40.4	1.8
Хонь	631412	140271	200754	286036	4351	100.0	22.2	31.8	45.3	0.7
Ямаа	1691339	219555	672203	793272	6309	100.0	13.0	39.7	46.9	0.4

Эх сурвалж: 2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Сүргийн бүтэц нийт сүрэгт эзлэх хувь

Зураг 13



3.Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж

3.1 Бэлчээрийн хүрэлцээ.

Газрын албаны 2018 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар манай аймгийн бэлчээрийн талбай 10.1 сая га талбайд хүрч малын тоо хонин толгойд шилжүүлснээр 3.8 сая толгойд хүрсэн байна. 2018 онд 100 га талбайд хонин толгойд шилжүүлснээр 37 толгой мал ногдож байна.


Бэлчээрийн хүрэлцээ

хүснэгт 23

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/ 2017
Бэлчээрийн талбай /мян.га/	11426.1	11372.2	11372.2	11363.8	11358.7	11357.8	11072.3	10302.1	10137.2	98.4
Хонин толгойд шилжүүлсэнээр 100 га бэлчээрийн талбайд ногдох малын тоо	13	16	18	21	23	26	30	36.9	37	100.3

Эх сурвалж: 2010-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Зураг 14



Манай аймгийн хувьд бэлчээрийн талбай их байгаа хэдий ч ус худгийн хүрэлцээ хангамж муу, мөн малчдын суурьшил ихтэй газруудад ашигт малтмалын болон хайгуулын лицензтэй ААНэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаагаас малын бэлчээрийн хүрэлцээ багасаж байна.

3.2 Малын тэжээлийн үйлдвэрлэлт.

2018 онд аймгийн хэмжээгээр 7625.87 тонн хадлан, 8.11 тонн таримал тэжээл , 983.7 тонн гар тэжээл, 32.1 тонн даршны ургамал, 3932 тонн хужир шүү, 571.6 тонн төмс, 17.1 тонн ногооны хаягдал хураан авч бэлтгэсэн байна.


Өөрийн хүчээр бэлтгэсэн хадлан нэр, төрлөөр

хүснэгт 24

тонн

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017
Хадлан өвс	3561.1	4909.7	4265.8	9625.9	5360	6844.2	5626.6	7625.9	135.5
Таримал тэжээл	31.9	17.9	28.5	36.6	247.5	57.2	17.7	8.11	45.8
Даршны ургамал	6.66	37.5	16.4	14.5	13.2	827.5	49.1	32.1	65.4
Гар тэжээл	439.9	803.3	519.5	726.5	1838.5	2598.3	1009.9	983.7	97.4
Хужир шүү	1937.9	801.6	1329.6	2771.6	4734.1	6189.6	3888.8	3931.6	101.1
Төмс ногооны хаягдал	51.1	83.6	46.7	81.8	20.5	16.9	38.9	17.1	44.0
Үр тарианы хаягдал		2	3.1	1.3	17	0	25.8	3.4	13.2
Сүрэл		6	0.06	0.5	10.5	10.1	14.1	2	14.2

Эх сурвалж: 2011-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн



Зураг 15

2018 онд аймгийн хэмжээгээр 7625.87 тонн хадлан хураан авсан нь өмнөх онтой харьцуулахад 35.5 хувиар өссөн үзүүлэлттэй харагдаж байна.

3.3 Тэжээлийн бүтэц, тэжээлийн хангамж

хүснэгт 25

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2018/2017
Бүгд	6028.56	6659.69	6209.66	13258.7	12245.5	16543.8	10670.9	12603.9	118.1
Хүчит	31.9	17.9	31.6	37.9	264.5	57.2	25.8	3.4	13.2
Шүүст	57.8	121.1	63.1	96.3	33.7	844.4	88	49.2	55.9
Бүдүүн	4001	5719.1	4785.4	10352.9	7213.2	9452.6	6650.6	8619.7	129.6
Бусад	1937.9	801.6	1329.6	2771.6	4734.1	6189.6	3906.5	3931.6	100.6
Хонин тодгойд шилжүүлсэн 1 мал ногдох тэжээл тэж.кг	3.4	3.3	3.3	4.9	4.2	7.1	2.8	3.6	128.6

Эх сурвалж: 2011-2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүн

Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг тооцлоо. Тэжээл бүрээр тодорхой итгэлцүүр ашиглан тэжээлийн нэгжид шилжүүллээ.

Дүгнэлт

Өмнөговь аймгийн 15 сумын 58 багт 2.6 сая толгой мал тоолуулж 2017 оныхоос 55.9 мянган толгой малаар буюу 2.1 хувиар буурсан байна. Нийт мал сүргийн тоо өмнөх оноос буурсан шалтгаан нь байгаль цаг уурын байдлаас шалтгаалан том малын хорогдол, төлийн хорогдол их гарсан мөн малчид хээлтүүлэгч мал тавиагүйгээс гарсан төлийн тоо өмнөх оныхоос буурсан зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.

2018 оны жилийн эцсийн мал тооллогоор аймгийн хэмжээгээр 7496 малтай өрх, үүнээс 5951 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Аймгийн хэмжээний нийт өрхийн 34.1 хувийг малтай өрх эзэлж байна. Мал аж ахуйн салбарт 9593 малчид ажиллаж байна. Нийт малчдын 44.8 хувь нь буюу 4269 эмэгтэйчүүд байна. Малчин өрхийн тоо өмнөх оныхоос 2.3 хувиар буюу 132 өрхөөр өссөн, малчдын тоо өмнөх оноос 0.4 хувиар буюу 42 малчнаар буурсан үзүүлэлт харагдаж байна. Малчин өрхийн тоо өссөн хэдий ч малчдын тоо буурсан нь өрх доторх мал аж ахуй эрхэлж буй гишүүний тоо буурч байгааг харуулж байна. Нийт малчин өрхийн 31.4 хувийг 16-34 насны залуучууд эзэлж байгаа бөгөөд, 53.7 хувийг 35-аас 59 насны хүмүүс харин үлдсэн 14.9 хувийг тэтгэврийн өндөр настай хүмүүс эзэлж байна. Малчдын тоог өмнөх оны малчдын тоотой харьцуулахад 16-34 насны залуучууд 72-оор буурсан бол, 35-59 насны хүмүүс 72-оор өссөн байна. Энэ нь залуу үе болох 16-34 насны залуучууд мал маллах сонирхолгүй, мал аж ахуйгаас хөндийрч байгаа нь харагдаж байна. Нэг малчин өрхөд 436 толгой мал оногдож байгаа нь өмнөх оноос 20 толгой малаар буурсан байна.

Нийт малчин өрхийн 77.3 хувь буюу 4599 өрх цахилгааны эх үүсвэртэй, 73.8 хувь буюу 4392 өрх телевизортой, 51.7 хувь буюу 3078 өрх автомашинтай, 48.7 хувь буюу 2898 өрх мотоциклтой, 0.1 хувь буюу 8 өрх трактортой байна. Өмнөх онтой харьцуулахад цахилгааны эх үүсвэртэй өрх 40 өрхөөр буюу 0.9 хувиар, телевизортой өрх 1.7 хувиар, автомашинтай өрх 10.4 хувиар, мотоциклтой өрх 0.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Трактортой өрх 42.8 хувиар буурсан байна. Өнөө үед мал аж ахуй эрхлэгчид малаа хариулахдаа адуу тэмээгээ унлага ачлагандаа ашиглах бус машин мотоциклийг түлхүү хэрэглэдэг болсон байна. Машин мотоцикль ашиглах нь малчдын цаг хугацаа, хүч хөдөлмөрийг маш их хөнгөвчилдөгтэй холбоотой юм.

1174.4 мянган толгой хээлтэгч тоологдсон нь өмнөх оноос 10.2 хувиар буюу 108.3 мянган толгойгоор өссөн байна. Төрлөөр авч үзвэл ингэ 9.0 хувиар, гүү 3.2 хувиар, үнээ 3.7 хувиар, Эм хонь 13.0 хувиар, Эм ямаа 9.6 хувиар тус тус өсчээ. Хээлтэгч мал нь нийт малын 45.2 хувийг эзлэж байгаа бөгөөд тэмээн сүргийн 34.1 хувийг, адуун сүргийн 33.5 хувийг, үхэр сүргийн 40.4 хувийг, хонин сүргийн 45.3 хувийг, ямаан сүргийн 46.9 хувийг тус тус эзэлж байна.

Гарсан төлийн 96.1 хувь нь буюу 399.9 мянган төл бойжуулсан байна. Бойжсон төлийн тоо 2017 оныхоос 264.3 мянган толгойгоор буурсан үзүүлэлттэй байна. Төл бойжилтыг төрлөөр нь авч үзвэл гарсан ботгоны 98.9 хувь, унаганы 93.7 хувь, тугалны 98.3 хувь, хурганы 97.7 хувь, ишигний 94.9 хувийг бойжуулсан байна. Төл бойжилт өмнөх оныхоос буурсан нь байгаль цаг уурын хүнд нөхцөл байдлаас болж төлийн хорогдол их гарсантай холбоотой.

Оны эхний малын 2.3 хувь нь буюу 62.0 мянган толгой мал хорогдсон нь 2017 оноос 50743 толгой малаар буюу 5.5 дахин өссөн байна. Нийт хорогдсон малын 78.9 хувийг ямаа сүрэг, 15.4

хувийг хонин сүрэг, 3.1 хувийг адуу сүрэг, 0.9 хувийг тэмээ сүрэг, 1.8 хувийг үхэр сүрэг тус тус эзэлж байна. Байгаль цаг уурын хүнд ширүүн нөхцөлд том малын зүй бус хорогдол маш их гарсан.

Оны эхний хээлтэгч малын 0.4 хувь нь буюу 11240 толгой хээлтэгч хээл хаяж, 22.4 хувьтай тэнцэх 593.4 мянган хээлтэгч сувайрсан байна. Төл өгөөгүй хээлтэгч малын тоо 604.6 мянгад хүрч түүний 98.1 хувийг сувайрсан хээлтэгч, 1.9 хувийг хээл хаясан хээлтэгч мал тус тус эзлэж байна. 16.7 мянган толгой хээлтүүлэгч мал тоологдож 2017 оноос 2.7 хувь буюу 471 толгойгоор буурсан байна. Өмнөх онтой харьцуулахад хээлтүүлэгч мал тэмээ, адуу, үхэр 3-н төрөл дээр өссөн, хонь ямаа 2 төрөл дээр буурсан үзүүлэлттэй байна. Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа тэмээн сүргийн хувьд 20-25 байхад 39, адуун сүргийн хувьд 12-15 байхад 8, үхэр сүргийн хувьд 35-45 байхад 22 байна, харин бог малын хувьд нэг хээлтүүлэгчид ноогдох хээлтэгчийн тоо 25-30 байхад хонь 66, ямаанд 126 байгаа нь үржлийн норм ихээхэн алдагдаж байгааг илтгэж байна. Нэг хээлтүүлэгчид оногдох хээлтэгчийн харьцаа өмнөх онтой харьцуулахад тэмээн сүрэг 2 хээлтэгчээр, хонин сүрэг 9 хээлтэгчээр, ямаан сүрэг 23 хээлтэгчээр тус тус нэмэгдсэн байна. Харин үхэр сүрэг 2 хээлтэгчээр буурсан байна.

Аймгийн хэмжээнд оны эхний малын 14.8 хувь буюу 393.9 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. Малын хэрэглээний зарлага 2017 оноос 81.3 мянган толгой малаар өссөн байна. Малтай нэг өрх дунджаар жилд 52.6 мал үүнээс 1.6 тэмээ, 1.6 адуу, 0.6 үхэр, 15.1 хонь, 33.8 ямааг хэрэглээндээ зориулж зарцуулсан байна. Аймгийн нийт өрхөөр тооцож үзэхэд нэг өрх дунджаар 18 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна. Зах зээлд худалдан борлуулсан болон аж ахуйн дотоодод хэрэглэсэн нийт малын 57.5 хувийг зах зээлд борлуулж, 42.5 хувийг аж ахуйн дотоодод хэрэглэсэн байна. Малтай нэг өрхөд дунджаар 28 толгой малыг зах зээлд борлуулж, 20 толгой малыг өөрийн хүнсэндээ хэрэглэсэн байна.

Нийт сүргийн 15.4 хувь нь буюу 399.9 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 38.8 хувь буюу 1007.3 мянган толгой нь нас гүйцсэн эр мал, 45.2 хувь буюу 1174.4 мянган толгой хээлтэгч, 0.6 хувь буюу 16.8 мянган толгой хээлтүүлэгч гэсэн бүтэцтэй байна.

Газрын албаны 2018 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар манай аймгийн бэлчээрийн талбай 10.1 сая га талбайд хүрч малын тоо хонин толгойд шилжүүлснээр 3.8 сая толгойд хүрсэн байна. 2017 онд 100 га талбайд хонин толгойд шилжүүлснээр 37 толгой мал ногдож байна.

Мал аж ахуйн салбарын үзүүлэлт болох малын тооны бууралтад байгаль цаг уурын таагүй нөхцөл ихээхэн нөлөөлсөн байна. Үүний хажуугаар мал эмнэлгийн үйлчилгээ орхигдож, удмын сан сүргийн бүтцийн харьцаа алдагдаж, өндөр ашиг шим өгдөг цэвэр эрлийз үүлдрийн малын тоо цөөрсөн, малын чанар муудсан зэрэг хүндрэлтэй асуудлууд байна.

Бэлчээрийн мал аж ахуйг цаашид хөгжүүлэхдээ бэлчээрийн даац, сүргийн бүтцээ зөв тохируулан, чанаржуулж өсгөх бодлогыг баримтлах хэрэгтэй байна.

Манай аймаг байгаль цаг агаар, газар нутгийн хувьд бусад аймгуудаас харьцангуй өвөрмөц онцлогтой бөгөөд ХАА-н салбар нь нийтдээ байгалиас шууд хамааралтай, эрчимжсэн аж ахуйн хөгжил сул байгаа зэрэг нь энэ салбарын цаашдын хөгжлийн талаар бодлого төлөвлөгөөтэй ажиллах зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм. Түүнчлэн ажилгүйдэл ядуурлын түвшинг байнга хэлбэлзүүлж байдаг энэ салбарт зах зээлийн өнөөгийн нийгэмд зохицсон бодлого хөтөлбөр гарган системтэйгээр хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

2018 онд аймгийн хэмжээгээр 7625.87 тонн хадлан, 8.11 тонн таримал тэжээл , 983.7 тонн гар тэжээл, 32.1 тонн даршны ургамал, 3932 тонн хужир шүү, 571.6 тонн төмс, 17.1 тонн ногооны хаягдал хураан авч бэлтгэсэн байна.

Сүүлийн 10 жил тус аймгийн газар тариалангийн салбар өсөлт бууралттай явж ирсэн бөгөөд тариалалт, хураан авсан ургац өссөн байгаа нь усан хангамжийн хүрэлцээг сайжруулж, удирдлага менежментээр хангаж ажиллаж байгаатай холбоотой юм.

Боловсруулсан

мэргэжилтэн:

С.Цэвэлмаа

Хянасан

**Статистикийн
хэлтсийн дарга:**

С.Бямбабаатар

Харилцах утас: 70533061, 70533439

E-mail хаяг:umnugobi_stat@yahoo.com
<http://www.umnugovi.nso.mn>

2019 оны 05 сарын 07